

**“УЛААНБААТАР” ЧУУЛГЫН
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2015 оны 07 дугаар сарын 10

Нийслэлийн Улаанбаатар чуулга нь 2015 оны эхний хагас жилд Монгол улсын Засгийн газрын тогтоол болон НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Үндэсний болон дэд хөтөлбөрүүд, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засгийн зорилтод тухайн жилд тусган дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2015 онд дараах ажлыг доорх үйл ажиллагааг зохион байгууллан ажиллав.

А. Бодлогын зорилт

1. Улсын Их хурал, Засгийн газар, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын холбогдох шийдвэрийн хэрэгжилт:

- Монгол Улсын Засгын газрын 2 тогтоолыг хяналтанд авч хэрэгжилтийлж ажилласан.

.2014 оны 12 дугаар сарын 15 –ны өдрийн журам батлах тухай 220 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Биелэлтийн хувь 90%-тай

2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 405 дугаар тогтоолын заалтын хэрэгжилийг хангуулан ажиллаж байна. Биелэлтийн хувь 90%

- Нийслэлийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 20-ны А/350 дугаар захирамжийн 3 дугаар заалийн дагуу ,татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах арга хэмжээг соёлын төв өргөөний тайзнаа зохион байгуулагдаж, чуулгын нийт уран бүтээлчид тусгайлан гаргасан хөтөлбөрийн дагуу урын сангийн дээжээсээ өргөж, 100% -ийн хэрэгжилттэй оролцсон. Өргөдөл гомдлыг эрчимжүүлэх тухай 2015 оны 06 дугаар сарын 25-ны А/554 дүгээр Захирамж. Биелэлтийн хувь 89,7%
Үүнээс: Архив албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн А/509 дугаар захирамжийн хувь 62,5% холбогдох ажлын жагсаалтыг гарган албан хаагч нарт үүрэг болгон өгч, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

- Засгын газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан тус байгууллагатай холбогдох заалт байхгүй болно.

3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Монголын нүүдэлчдийн үндэсний сонгодог, уламжлалт соёлын биет бус өвийн ховор хосгүй төрөл, зүйл болох Монгол Алтайн Урианхайн цуур хөгжим, цуурдах урлаг нь үеэс үед өвлөгдөн уламжлагдсаар ирсэн боловч, өнөө цагт өвлөн уламжлагч эзэнтэйгээ хамт мартагдан алга болж, устах нөхцөл байдалд хүрээд байна. “Улаанбаатар” чуулга нь үндэсний урлагийнхаа дэг, жаягийг алдагдуулалгүйгээр Олон улсын жишигт нийцсэн шинэ, шинэлэг уран бүтээл туурвин иргэд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж сонин, телевиз, FM радионуудтай хамтран ажиллаж байна

“Улаанбаатар” чуулгын тайзнаа 2015 оны 5 дугаар сарын 04-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ныг дуустал Улсын хэмжээний томоохон шоу “Авьяаслаг монголчууд”-ын телевизийн бичлэг манай тайзнаа зохион байгуулагдаж манай чуулгын хөгжимчин

Б.Мягмарцэрэн, хөгжимчин Х.Бархүү нар оролцон эхний шалгаруулалтандаа тэнцсэн байна.

4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засгийн нийгмийн 2015 оны зорилтын хэрэгжилт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 4.1.5 заалт буюу 1 ажил тусгагдсанаас 2015 оны хагас жилийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй байна.

5. 4.1.5 Мансууруулах бодисын хорт нөлөөг таниулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

Зорилтын хүрээнд:

Тус чуулга нь үзвэр үйлчилгээ, үйл ажиллагааны өмнө “Тамхины хяналтын тухай” хууль гарсантай холбогдуулан үзвэрийн өмнө үзэгчдийн танхим, чуулгын байранд утаат тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон анхааруулга, санамж бүхий аман сурталчилгааг тогтмол хийдэг бөгөөд зурагт наалтуудыг шаардлагатай газруудад байрны засварын ажил дууссаны дараагаар байршуулахаар ажиллаж байна. “Тамхины хяналтын тухай” хууль, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулиудыг албан хаагчдад сурталчлан таниулж буруу зуршлаас татгалзах чиглэлээр 2014 оны 02 сарын 12-ны өдрийн 07 дугаар хурлаар албан хаагчидтай чөлөөт ярилцлага хийлээ.

Албан хаагчдаас тамхи татдаг албан хаагчдын судалгааг авч бүх нийтийн хурал дээр тамхинаас гарахыг уриалав.”Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн нийгэмлэг”-тэй хамтран тамхины хор хөнөөллийн тухай, мөн тамхинаас гарах үед баримтлах хоолны дэглэмийн тухай хичээлийг боловсруулан албан хаагчдад онлайн сургалтыг оруулав.

Залуучууд, өсвөр үеийнхнийг архи, тамхи, мансуурлын хорт хэрэглээнээс татгалзах, урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг соёл урлагийн бүтээлээр дамжуулан хүргэх.

6. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагч нарын байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас жилийн байдлаар гарган НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

7. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн ажил төрлийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдлагуудын 14 хоног тутмын уулзалтаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилтийн тухай тайланг тухай бүрт нь www.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулсанг соёл урлагийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллааг зохион байгуулан ажилласан. .

Ажилтнуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Ажилтнуудын хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2015 оны 07 дугаар сарын -ны өдөр дүгнэсэн. Хөдөлмөрийн гэрээ 13, Үр дүнгийн гэрээ 5 ажилтан байгуулж ажилласан.


8. Архив, албан хэрэг хөтлөлтийн байдал

- Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, маркетинг, Хүний нөөц, санхүүгээс архивын баримт хүлээн авах хуваарь гарган батлуулан ажилласан.
- Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, маркетинг, Хүний нөөц, санхүүгээс Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтаа хүлээн авсан
- Архивын баримтаа байнга түр 70 жилээр ангилж авсан
- Архивын баримтаа эмхэлж цэгцэлсэн
- Нийслэлийн засаг даргын 2015 оны А/172 дугаар захирамжын дагуу 2014 оны захирамжлалын баримтаа төрийн архивын www.lavlagaa.ub.gov.mn шивж оруулсан
- Архивын тоон тайлангаа 03 сарын 25-ны өдөр www.archiv.ub.gov.mn тоон тайлан оруулсан
- Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан 2015 оны 06 сарын 19-ны 9 -17 цаг хүртэл “Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг хангах” сэдэвт нэгдсэн сургалтанд суусан
- Нийслэлийн засаг даргын 2015 оны А/177 дугаар захирамжийн Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын журмын дагуу Нийслэлийн архивын газрын газартай төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааны хүрээн хамтран ажиллах ажил, үйлчилгээний гэрээ 2015 оны 02 сарын 25-ны өдөр байгуулан хамтран ажиллаж байна.
- Нийслэлийн Улаанбаатар чуулгын 2006-2014 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх, архивын баримтаа эмхлэн цэгцлэх ажлын хүрээнд архивын ажилтан Б.Сувд-Эрдэнэ Нийслэлийн Архивын газрын ажилтан Н.Цацралтуяа, Б.Сарантуяа нараас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 2006-2014 оны архивын баримтад 2015 оны 04 дүгээр сарын 02-ноос 2015 оны 05 дугаар сарын 25-ныг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

9. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Тайлант хугацаанд өссөн дүнгээр нийт 27 хүсэлт шийдвэрлэсэн байна. Үүнд: “ажилд орох хүсэлт”-13, “ажлаас өөрийн хүсэлтээр бүр чөлөөлөгдөх хүсэлт”-6, “ажлаас түр чөлөөлөгдөх хүсэлт”-4, “хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болж ажилдаа эргэн орох хүсэлт”-1, “буцалтгүй тусламж хүссэн хүсэлт”- 3-ыг тус тус шийдвэрлэсэн байна. Эдгээр хүсэлтийг хугацааны хувьд ангилбал: 1 дүгээр улиралд “16”, 2 дугаар улиралд “11” хүсэлт шийдвэрлэсэн байна.

График 1.2 – “Хүсэлт” улирлаар /өссөн дүнгээр/”



2015 оны эхний хагас жилийн байдлаар ирсэн бичиг – 72 , хариутай – 62, хариугүй – 10, шийдвэрлэх шатандаа – 3 байна. Үүний албан тушаал задлан үзвэл:

Ирсэн бичгээс

Маркетингийн менежер Л.Одгэрэл – 19

Хүний нөөцийн менежер Б.Гансүх- 14

Нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг-9

Найруулагч П.Урнаа-10

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг–3 албан бичиг ирснийг шийдвэрлэж холбогдох газарт нь хариу хүргүүлж ажилласан.

Явуулсан бичиг – 126

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг 63

Хүний нөөцийн менежер Б.Гансүх- 21

Нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг-15

Маркетингийн менежер Л.Одгэрэл – 12

Найруулагч П.Урнаа-4

Байгууллагын хэмжээнд нийтдээ 54 тушаал боловсруулж үүнээс А – 09, Б – 45 тушаал байна.

Дээд газраас ирсэн тогтоол тушаал 2, хэрэгжилт **95%** байна.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган мэдээлж ажилласан.

Б. Үндсэн үзүүлэлт / тухайн байгууллагын дүрмээр Хүлээсэн үндсэн үүрэг /

Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын бодлого шинэчлэлийн хүрээнд уран бүтээлийн санг бий болгож үйл ажиллагааны олон талд тоглолтыг өөрийн тайзнаа туурвиж, өөрийн төлөвлөгөөний дагуу ажилласнаар байгууллагын нэр хүнд өсч, ард иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэн ажиллаж байна.

Албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангахын тулд байгууллагынхаа ур чадварын нэмэгдэл олгох журмыг чуулгын даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны А/06 тоот тушаалаар шинэчлэн мөрдөж ажиллаж байна.

Албан хаагчдынхаа дунд сургалт зохион байгуулж мөн мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллахаас гадна, санал хүсэлтийг нь авч тэдний дунд хүссэн сургалтыг нь зохион байгуулах, мэргэжлийн сургуульд суралцах, сургалтанд хамрагдан зэрэг дэв, ур чадварыг дээшлүүлэх боломжоор хангах зорилготой ажиллаж байна.

Тус чуулгын уран бүтээлчид нь Нийслэлээс зохион байгуулсан урлаг соёлын үйл ажиллагаанд оролцохоос гадна гадаадын олон оронд урлаг, соёл, өөрийн орныг сурталчилах хэд хэдэн үйл ажиллагаанд оролцов.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд соёл урлаг, аялал жуулчлалын томоохон үйл ажиллагаануудыг зохион байгууллахаар 40 гаруй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран гэрээ байгуулж, тоглолтыг өргөн барихад бэлэн болоод байна.

• **Удирдлага, зохион байгуулалтын ажил:**

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн архивын газраас зохион байгуулж байгаа 2015 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр нийслэлийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд эхний хагас жилийн ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

1. “Улаанбаатар” чуулгын захиргааны албан хаагч нараас 2015 оны 03 дугаар сарын 15 ны өдөр төрийн албан хаагчийн албан хэрэг хөтлөлтийн мэдлэг шалгах сорилын шалгалтыг авав.

2. 2015 оны 03 дугаар сарын 23, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өрүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг оров. Сургалтанд чуулгын захиргааны нэгжийн 10-н албан хаагч хамрагдав.

3. Улаанбаатар чуулгын гоцлол дуучин Дуламын Баасанжав нь 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Дунгаамаа” дуун цэнгүүнийг өөрийн тайзнаа тоглолоо.

4. “Улаанбаатар” чуулгын тайзнаа 2015 оны 5 дугаар сарын 04-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ныг дуустал Улсын хэмжээний томоохон шоу “Авьяслаг монголчууд”-ын телевизийн бичлэг манай тайзнаа зохион байгуулагдаж манай чуулгын хөгжимчин Б.Мягмарцэрэн, хөгжимчин Х.Бархүү нар оролцон эхний шалгаруулалтандаа тэнцсэн байна.

- **Соёл урлагийн үйл ажиллагаа:**

2015 оны эхний улиралын байдлаар зохион байгуулагдсан соёл урлагийн үйлчилгээ, тайзан дээр явуулсан үйл ажиллагаануудыг багцлан тайланд тусгалаа.

Зөвхөн үндэсний хөгжим дуугаар урын сангаа хязгаарлахгүй бусад төрлөөр уран бүтээл хийх чадвартай хамт олон бүрдүүлэн ажиллаж байна. “Улаанбаатар” чуулга 2015 оны 06 сарын 22-ны өдрийн байдлаар дараах томоохон үйл ажиллагаануудыг санаачлан зохион байгуулсан байна. Үүнд:

1. 2015.04.01. Монгол бөхийн өргөө Урлаг.mn-ийн тоглолт
2. 2015.04.10. Мишээл экспо “Noreca - 2015” тоглолто
3. 2015.04.10. Мишээл экспо “Noreca - 2015” тоглолт
4. 2015.04.12. Хангарьд спорт заал Цэнгээнт бүжгийн уралдаан
5. 2015.04.15. УБ ресторан “УБ хөрөнгө оруулалт-2015” чуулга уулзалтын хүндэтгэлийн хүлээн авалт
6. 2015.04.18. Дундговь Мандалговь “Ардчилсан нам”-ын 25 жилийн ойн тоглолт
7. 2015.04.30. УБЧ Жуулчин хүлээн авдаг компаниудад зориулсан тоглолт
8. 2015.04.30. УБЧ Исүсийн сүмийн захиалгат тоглолт
9. 2015.05.03. УБЧ УБЦДҮС ТӨХК-ийн “Урлагийн наадам”-ын тоглолт
10. 2015.05.05. МҮОНТВ “2016 онд УБ хотноо зохиогдох Ази-Европын 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтын албан ёсны лого, цахим хуудас нээх ёслолын ажиллагааны нээлт”-ийн үйл ажиллагаа
11. 2015.05.11. СТӨ “Дэлхийн хот УБ” татвар төлөгчдийн өдрүүдийн нээлт, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа
12. 2015.05.14. Хангарьд ордны 16 давхар НЗДТГ-ын хуулийн хэлтэс 21 аймгийн хуулийн хэлтсийн дарга нарт зориулсан хүндэтгэлийн тоглолт
13. 2015.05.14. УДБЭТ “Мөнгөн мод” шагнал гардуулах ёслолын ажиллагааны тоглолт
14. 2015.05.15. СТӨ “Уралын хавар” тоглолт
15. 2015.05.16. МҮОНТВ Өглөө хөтөлбөр
16. 2015.05.18. СУИС Оюутан театр УБЧ-ын хөгжимчин О.Чинбатын диплом хамгаалах тоглолт
17. 2015.05.22, 25 Монгол Кувейтийн хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн тоглолт
18. 2015.05.27. УБЧ МУСТА Д.Баасанжавын “Дунгаамаа” тоглолт
19. 2015.05.29. ТТО МУГЖ Т.Баяраа, МУГЖ Ш.Даваахүү нарын “Монгол хатдын дуу” тоглолт
20. 2015.05.31. Баянхошууны эцэс НИТХ-ын төлөөлөгч Ш.Одгэрэлийн захиалгат тоглолт
21. 2015.05.31. 96-р сургууль НИТХ-ын төлөөлөгч Ц.Алтанцэцэгийн захиалгат тоглолт
22. 2015.06.01. Чингис хааны талбай Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан тоглолт
23. 2015.06.05. Чингис хааны талбай “Венийн вальс” тоглолт
24. 2015.06.06. Хотын орлогч дарга Ц.Энхцэнгэлийн захиалгат тоглолт
25. 2015.06.15. Хангарьд ордны 16 давхар ЗДТГ гадны зочид хүлээн авах тоглолт

26.2015.06.16. Irish pub ЗДТГ гадны зочид хүлээн авах тоглолт

Улаанбаатар чуулга нь үйл ажиллагаагаа тэлэн өргөжүүлж, ард иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж өсч цаашид “театр”-ын статустайгаар ажиллах хүсэлтэй байгаа тул дүрмийн төслөө боловсруулан холбогдох газрууд руу хүргүүлж ажиллахаас гадна, чуулгын тоглолтын тасалбарыг “monda.mn” цахим хуудсаар худалдах системд шилжин ажиллаж байна.

2015 оны 04 дүгээр сарын 24, 25 тоглогдсон Дэлхийн суут бүтээл болох “**АРИУН ХАВРЫН ТАХИЛГА**” этно балетын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

В. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

1. Байгууллагын дотоод удирдлагын програм нэвтрүүлсэн байдал

- Байгууллагынхаа дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлж байгууллагын чадавхийг сайжруулах зорилгоор **И-Оффис** програмд ажилтнуудын талаарх мэдээллийг оруулж, албан хаагч тус бүр дээр цахим хаяг нээж тэдэнтэй харилцахад хялбар болж байна.
- Мөн фэйсбүүк хуудсанд ажилтан албан хаагчдыг багтаасан хаалттай групп үүсгэж нийт албан хаагчдад холбогдох мэдээ, мэдээлэлийг тогтмол байршуулж ажилласан байна. Энэхүү хуудсанд хагас жилийн байдлаар: Даргын тушаал-5, фото мэдээ-53, судалгаа статистик мэдээ 3 нийт **61** мэдээллийг байршуулсан.

2. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

- Байгууллагын мэдээллийн мэдээллийн ил тод байдлыг хангах гол хэрэглүүр болох веб сайтыг шинэчилж, фэйсбүүк, твиттер хуудсын ашиглалт, үйл ажиллагаа, баяжуулалтыг сайжруулж, түүнд хяналт тавьж ажиллаж байна.
- 2015 онд зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2015 оны чуулгын даргаар батлуулж, байгууллагын www.ulaanbaatarчуулга.mn цахим хуудаст байршуулсан.
- Чуулгын цахим хуудас болох www.ulaanbaatarчуулга.mn –ын хэвийн үйл ажиллагаа алдагдсан тул шинэчилж Датаком ХХК-аас www.ubchuulqa.nm нэртэй домэйн нэр авч цахим хуудсыг бүрэн шинэчлэх ажил хийж байна.
- Чуулгын тоглолтын талаарх мэдээ, мэдээлэл, чуулгын маркетингийн зар сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, сошиал маркетингийн facebook, twitter, google+ сувгууд болон урлагийн мэдээ мэдээлэлийг голчлон түгээдэг вэб хуудсууд, сонин сэтгүүл, телевизийн гэрээтэй сувгуудыг ашиглан олон нийтэд сурталчилгаагаа хийсэн.
- Тайзнаа тоглох уран бүтээлүүдийн талаарх мэдээ, мэдээлэл, тасалбарын борлуулалтын тал дээр анхаарч цахим тасалбарыг энх удаа чуулгын үйл ажиллагаанд нэвтрүүлж, www.monda.mn сайтаар үзэгч олон маань тоглолтын тасалбарыг захиалан цаг хугацаа хэмнэх бүрэн боломжийг нээн ажиллалаа.
- Өмнөх онд гэрээтэй байсан телевизүүдийн хэрэглэгчийн хандалтын судалгааг үндэслэн зар сурталчилгааг үр дүнтэй байлгах үүднээс шинээр санал хүргүүлж бартерын гэрээгээр хамтарч ажиллах телевизийн гэрээг шинэчилсэн. Хамтран ажиллах сайт, сонин сэтгүүлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг мөн ижил сонгож ажиллаж байна.
- Төрийн албан хаагчдын 2014 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв бөглүүлэн авч www.meduuleg.iaac.mn цахим хуудаст цаг хугацаанд нь бүртгүүлсэн.

3. **Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

Шинээр ажилд орсон 13 албан хаагчид тухай бүрт хувийн хэрэг бүрдүүлэв. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн №220 тоот тогтоолын дагуу “Ажиллагсдад үр дүнгийн шагнал, урамшуулал олгох журам”-ыг гарган нийт албан хаагчдаас хагас жилийн ажлын тайланг авч албан хаагч нэг бүрийн ажлыг үнэлж дүгнэв. Гадаад эх үүсвэрт шаардлагатай 6 төрлийн судалгааг тайлант хугацаанд хүргүүлэн ажиллав. Үүнд:

-Нийслэлийн Соёл Урлагийн газарт :

1/ 8%-ийн зээлтэй албан хаагчдын судалгаа

2/ Орон тоо, бүрэлдэхүүн хөдөлгөөний судалгаа

-Сүхбаатар дүүргийн цэргийн штабт: 1/ Цэргийн насны албан хаагчдын судалгаа

Чуулгын дотоод үйл ажиллагаанд шаардлагатай албан хаагчдын нийгмийн байдлын судалгаа

- “Ub ensemble staff” группийг Facebook дээр ажиллуулж мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь хүргэж ажиллаж байна.

-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг зөв оновчтой ойлгомжтой дүгнэхийн тулд “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” журмыг шинэчлэн боловсруулж шинэ журмын дагуу нийт албан хаагчдыг дүгнэж нэмэгдэл хөлс олгов.

нөөцийн чиглэлээр 25 арга хэмжээнд 45 ажилтан

-41 хурал зөвлөгөөнд 167 ажилтан хамрагдсан байна.

Мэдээллийн ил тод байдал

1. Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг цахим хуудсаар мэдээлсэн байдал

-Чуулгын уран бүтээл, өдөр тутмын үйл ажиллагааны талаар мэдээллийг ulaanbaatarчуулга.mn цахим хуудас болон facebook дэх ubчуулга, twitter дэх ub_chуулга хуудсаар тогтмол түгээж байна.

-UBS, ETV, TV9, Боловсрол суваг, NTV, RoyalHD, TV5 зэрэг сувгуудаар шинэ уран бүтээлийнхээ талаар мэдээлэл сурталчилгаа хийж хамтран ажиллаж байна.

Grandnews.mn, news.mn, new.mn, urlag.mn, mongolzaluus.com, ikon.mn цахим хуудсуудаар тоглолт, уран бүтээлийн талаар мэдээлэл дамжуулав.

Гэрэгэ, Гоодаль, Нийслэл Гайд, Grand сэтгүүл, Засгийн газрын мэдээ, Нийслэл таймс сонинд нийтлэл, сурталчилгаа байршуулав.

-“Улаанбаатар” чуулгын урын сангийн бодлогын шинэчлэлийн хүрээнд уран бүтээлийн санг бий болгон шинэ уран бүтээл болох 2 мюзиклийг өөрийн тайзнаа 2014 онд тоглосон бөгөөд одоо 4 дүгээр сард “Ариун хаврын тахилга” контенперари балетыг өөрийн тайзнаа тоглож үзэгчдээс өндөр үнэлэлт авав.

-Хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний сургалт, урлагийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаас гадна төрөл бүрийн сургалт, дугуйланг тогтмол хичээллүүлж байна. Залуучуудад зориулсан гитар хөгжмийн сургалт, электро бүжгийн сургалт, тулааны урлагийн сургалтын “Улаанбаатар Кендо” клубтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Залуу хамтлаг дуучидтай хамтран ажиллаж, тэднийг тоглолтын заал, бэлтгэл хийх өрөө, тоглолтын маркетинг зэрэг дээр хамтран ажиллаж хугацаа товлон, амьд хөгжмийн тоглолтуудыг зохион байгуулж эхлээд байна.

Төсөв, санхүүгийн ил тод байдал

- 2015 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй.

-2015 оны 1-6 дугаар сарын мэдээ, Нийслэлийн аудитын газраас 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн дүгнэлтийг хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан.

- 2015 оны жилийн төсөв, сар улирлын тайлан мэдээ болон холбогдох баримтуудыг хуулийн хугацаанд нь мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг цаг тухайд нь хангаж Нийслэлийн засаг даргын захирамжаар батлагдсан орлого зарлагын гүйлгээг өөрийн байгууллагын цахим хуудас болон сайтад байршуулан ажиллаж байна.

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийг эхний хагас жилээр хуралдуулж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгийг бүртгэлд авах, хагас жилээр эд хөрөнгийн тооллого явуулах зэрэг шийдвэрүүдийг тусгаж ажиллалаа

. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтсээс 2012-2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж санхүүгийн ямар нэгэн төлбөр зөрчилгүй гарсан. Нийслэлийн Соёл урлагийн газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Нийслэлийн Аудитын газраас аудит хийсэн дүгнэлтийг иргэдэд нээлттэй байршуулсан 2013 оны Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй стандарт дүгнэлт авч ажилласан

Г. ШИНЭ САНААЧИЛГА, ҮР ДҮН

1. Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил

Нийслэлийн Улаанбаатар чуулгын хамт олон ХХ зууны алдарт хөгжмийн зохиолч И.Ф.Стравинскийн суут туурвил “Ариун хаврын тахилга” балетыг 2015 оны 4-р сарын 24, 25-нд 19:00 цагт чуулгынхаа тайзнаа тоглолоо.

Уг балетыг “Улаанбаатар” чуулга “Төгөлдөр сан”-гийн ивээн тэтгэлгээр Монголд анх удаа үндэсний хөгжимд найруулан, ардын бүжгийн уламжлалыг модерн бүжигтэй хослуулан шинээр тавьсан нь Монголын ардын хөгжмийн зэмсгийн уран сайхны илэрхийллийг нээж таниулсан, Монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг харуулсан уран бүтээлийн томоохон эрэл хайгуул боллоо.

И.Ф.Стравинскийн “Ариун хаврын тахилга” балет нь 1913 онд Парист анх тоглосон үедээ маш их шүүмжлэлийг дагуулж, шуугиан тарьсан ч, хожим нь энэ бүтээл дэлхийн хөгжмийн түүхэнд шинэ үеийг эхлүүлсэн, хөгжмийн цоо шинэ хэллэгтэй, орчин үеийн балетын дэглэлтэд нөлөөлсөн сод бүтээлд тооцогдох болсон билээ.

Уг балет “Газар шороогоо үнсэх нь”, “Агуу их тахилга” гэсэн хоёр үзэгдлээс бүрдэнэ. Найрал хөгжмийн “Эхлэл хэсэг” хаврын байгаль сэргэн аажмаар цэцэглэж буйг зурагладаг. Бүжиг, тоглоом наадам, зан үйлийн ёслолууд ээлжлэн улмаар үхэх тавилан оноогдсон бүсгүйн “Агуу их-ариун бүжиг”-ээр төгсдөг.

Ариун хаврын тахилга балетыг И.Стравинский 120 гаруй хүний бүрэлдэхүүнтэй симфони найралд зориулан анх бичсэн бол энэ удаад Улаанбаатар чуулгын 24 хүний бүрэлдэхүүнтэй “Хангарьд” үндэсний найрал хөгжим шинэ найруулгаар тоглож байгаа нь Монголын мэргэжлийн хөгжимчдийн ур чадварыг илтгэн харуулсан юм. Хөгжмийг “Улаанбаатар» чуулгын захиалгаар Монголын чадварлаг залуу хөгжмийн зохиолч МУСТА Х.Алтангэрэл найруулж, бүжгийг МУСТА бүжиг дэглээч Д.Энхгэрэл дэглэж, МУ-

ын УГЗ, удирдаач МУУГЗ Н.Туулайхүү “Хангарьд” үндэсний хөгжмийн найрлыг удирдан тоглуулуулсан билээ.



“Ариун хаврын тахилга” этно балетын санхүүжилтийг бүрдүүлэхийн тулд энэхүү уран бүтээлийн төслөө Монголын Урлагийн зөвлөлд танилцуулснаар, урлагийг дэмжигч “Төгөлдөр сан”-гийн тэргүүн Х.Отгонтуяа болон тус сангийн хамт олон ивээн тэтгэгчээр, Монголын урлагийн зөвлөл хамтран зохион байгуулагчаар ажиллаа.



Мөн “Туул Ротари” клуб, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хамт олон энэхүү тоглолтын тасалбарыг худалдан авч үзсэнээр тус тоглолтын орлогоос “Туул Ротари” клубын 10 жилийн туршид хэрэгжүүлж байгаа “Хүүхдийн зүрх” төслийн зүрхний өвчтэй хүүхдийн эмчилгээний зардалд 20%-ийг нь хандивлаж, сайн үйлс бүтээгч хамт олны тоонд албан ёсоор нэгдлээ.

Нээлтийн тоглолт болох 2015 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн тоглолтонд Нийслэл хотын удирдлагууд, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн төлөөлөл, Монголын ардын болон сонгодог урлагийн нэрт зүтгэлнүүд, Монголын орчин цагийн хөгжмийн урлагийн нэрт төлөөлөгчид, хөгжим, бүжгийн мэргэжилтнүүд болон урлагт хөрөнгө оруулагч бизнесийн салбарын нэр хүндтэй зочид, хөгжим судлаачид, урлаг судлаачид урилгаар хүрэлцэн ирж үзлээ. Тэдний зүгээс “Улаанбаатар чуулгын жил гаруй хугацаанд бэлтгэж үзэгч олондоо өргөн барьсан энэхүү бүтээл нь бидэнд гайхалтай шинэ мэдрэмжийг төрүүллээ” гэж дүгнэсэн юм. Харин удаах өдрийн тоглолтыг “Туул

Ротари” клубын гишүүд болон сонгодог урлагт хайртай үзэгчид, мэргэжлийн чиглэлээр суралцагч, оюутан залуус хүрэлцэн ирж сонирхсон ба халуун алга ташилтаар манай уран бүтээлчдэд урам хайрласан нь бидний шинэ бүтээлд өгсөн өндөр үнэлгээ болсон.



Монгол улсын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Шарав шинэ бүтээлийн талаар үнэлэхдээ “Улаанбаатар чуулга дэлхийд анх удаа үндэсний хөгжмөөр 20-р зууны суут бүтээлийг хөгжимдлөө. Үнэхээр гайхалтай бүтээл туурвисан байна.” гээд манай уран бүтээлчдэд улам их амжилтыг хүсэж, талархал илэрхийлсэн юм.

Хэвлэл мэдээлэлийн сурталчилгааг “UBS”, “Монгол” HD, MYOHT, ETV, TV5, “Стар тв” телевиз болон “Гранд сэтгүүл”, “Нийслэл гайд”, “Гоо даль”, “Гэрэг” сэтгүүл, “Засгийн газрын мэдээ”, “Нийслэл Таймс”, “Үндэсний шуудан”, “Үнэн” сонин, urlag.mn, news.mn, ikon.mn, grandnews.mn, mongolzaluus.com сайтуудаар хийж, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Монголын хүүхдийн Ордон, “Улаанбаатар” чуулгын гадаах дэлгэцүүд дээр уран бүтээлийн “Язгуур” нэгдлийн бүтээсэн “Ариун хаврын тахилга” этно балетын тухай нэвтрүүлгийг олон нийтэд цацаж танилцуулсан.

Тоглолтын өмнө зочдыг угтах танхимд улаан дарс, цэвэр ус зэргийг хундагалж бэлтгэсэн бөгөөд үзэсгэлэнгийн танхимын хананд Төрийн соёрхолт зураач Цэгмидийн бүтээлүүдийг байрлуулж, төв хэсэгт зассан LED дэлгэц дээр бүтээлийн талаарх нэвтрүүлэг, шторк, баннер ээлжлэн гаргаж танилцуулсан.

Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөө хэмнэх бодлогын чанартай арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал


-2015 оны төсөвт уран бүтээлийн зардал тусгагдаагүй тул чуулгын тайзан дээр тоглогдох уран бүтээлийг гадны байгууллын оролцоотойгоор ивээн тэтгүүлж, гэрээ хийн ажиллаж байна.

-Нийслэлийн Засаг даргын 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/637 дугаар захирамжаар 62 хүний орон тоо бүтэцтэйгээр ажиллахаар батлагдсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааны зардал хэмнэх, төсвийн зардлыг бууруулах, төсвийн зардлыг хэмнэхийн тулд сул орон тоон дээр хүн нэмж ажиллуулахгүй уран бүтээлчдын ажлын байрны тодорхойлолтыг дахин батлаж цалингийн зардлыг хэмнэн ажиллаж байна.

Д. ХЭРЭГЛЭГЧИИН ҮНЭЛГЭЭ

1. Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн байдал


Уг судалгаанд нийт 100 хүн хамрагдсанаас 62 эмэгтэй, 38 эрэгтэй хүн байлаа.



2. Тэдгээр судалгаанд хамрагдагсдыг насны ангиллаар авч үзэхэд 5% нь 10-15 насны, 17% нь 16-20 насны, 32% нь 21-30 насны, 28% 31-40 насны, 18% нь 41-ээс дээш насны хүмүүс оролцсон байна.



3. Судалгаанд оролцогчдын 50% нь урлагийн тоглолт үзэх, 15% нь тайзны үйлчилгээ авах, 35% нь өөрсдөө болон хүүхдээ сургалтанд хамрагдуулахаар ирсэн хүмүүс байсан.




4. Та жилд хэдэн удаа үзвэрийн газраар үйлчлүүлдэг вэ? гэсэн асуултанд 19% нь зөвхөн 1 удаа, 48% нь 2-3 удаа, 22% нь 4-5 удаа, 11% нь 6 ба түүнээс дээш удаа үзвэр үйлчилгээний газраар үйлчлүүлдэг болохоо хариулсан байна.



5. Судалгаанд оролцогчдын 31% нь хошин шогийн тоглолт, 29% нь кино, 12% нь жүжгийн төрөл, 8% нь мюзикл, 11% нь амьд хөгжмийн тоглолт, 9% нь нийтийн дууны концерт үзэх сонирхолтой гэсэн хариулт өгсөн байна.



6. “Улаанбаатар чуулга”-ын орчин нөхцөл болон тоглолтонд сэтгэл хангалуун байна уу? гэсэн асуулгын үр дүнд нийт 85% нь тийм гэсэн хариултыг өгсөн байна.



7. Хэрэглэгчдээс манай тоглолтын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултад 40% нь телевизээс, 20% нь фм радиогоос, 40% нь веб хуудас, фэйсбүүк болон твиттер хуудаснаас мэдээлэл авдаг гэж хариулсан байна.



ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь 18-30 насны хүмүүс байснаас гадна эмэгтэйчүүд байсан. Манай байгууллагын орчин нөхцөл хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн таатай байдаг боловч чуулгын гол уран бүтээл болох мюзиклыг үзэж сонирхох үзэгчдийн хандлага бага байгаа нь шинээр хөгжиж байгаа урлагийн төрөл болох мюзиклын талаарх сурталчилгааг мэдээллийн идэвхитэй сувгийг ашиглан, хүмүүст хүргэх таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна. Хэрэглэгчдийн 80% нь “Улаанбаатар чуулга”-д тоглогдох аливаа тоглолтуудын талаарх мэдээллийг интернет болон телевизээс авдаг тул идэвхижүүлэлтийг эдгээр сувгуудаар хийвэл илүү үр дүнтэй болох нь харагдаж байна.

ХЯНАСАН:
ДАРГА

Р.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ӨНӨРЦЭЦЭГ

